



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 07 сарын 27 өдөр

Дугаар А/29

Улаанбаатар хот

Орчуулагчийн зардал төлөх тухай

Шүүхийн захиргааны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3, 22.1.5 дахь заалт, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 11.5 дугаар зүйлийн 1, 11.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Улсын Дээд шүүхийн хяналтын шатны Эрүүгийн хэргийн шүүх хуралдааны 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 04 дугаартай тогтоолын тогтоох хэсгийн 1 дэх хэсгийг үндэслэн Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн ТУШААХ нь:

1. Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдөр хянан шийдвэрлэгдсэн Юн Жин-д холбогдох эрүүгийн хэрэгт шүүгдэгчийн орчуулагчаар оролцсон Л.Энхжаргалын тайлбар, хүсэлтийг үндэслэн 100.000 /нэг зуун мянган/ төгрөгийн орчуулагчийн зардлыг нөхөн төлж, олгосугай.

2. Орчуулагчийн зардлыг төсвийн зохих зардлаас гаргахыг Санхүү, хангамж, үйлчилгээний хэлтсийн дарга Н.Булгамаад зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.НАРАНПҮРЭВ

050234